


**“ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 25/22 дугаар тогтоолоор “Дулааны тавдугаар цахилгаан станц” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулж, дүрмийг баталсан. Улмаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор дүрэмд өөрчлөлт оруулж, үүнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/181 дүгээр захирамжаар байгууллагын зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. Захирамжийн дагуу тус байгууллага нь Техник хяналтын хэлтэс, Захиргаа, хүний нөөцийн хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг, 2 дугаар хавсралтаар Цалин хөлсний журмыг, мөн өдрийн А/13 дугаар тушаалаар Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг, 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/53 дугаар тушаалаар байгууллагын Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг, мөн өдрийн А/54 дүгээр тушаалаар байгууллагын ажилтны Ёс зүйн дүрмийг тус тус баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2026 оны эхний улиралд ажилтнуудыг чадавхжуулах хүрээнд дараах сургалтад хамруулаад байна. Үүнд:

1. 03 дугаар сарын 10-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Төрийн цахим үйлчилгээний газраас хамтран зохион байгуулсан ил тод байдлын сургалтад тус байгууллагын Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга хамрагдав.





2. 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх” сургалтад тус байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжилтэн хамрагдав.

3. 03 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд нийслэлийн харьяа байгууллагуудын дунд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Байгууллагын стратегийн төлөвлөлт ба тэнцвэржүүлсэн үнэлгээний картыг нэвтрүүлэх нь” сургалтад тус байгууллагын Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга хамрагдав.





Ажилтнуудын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх хүрээнд шаардлагатай техник хэрэгсэл, төхөөрөмжөөр тухай бүр ханган ажиллаж байна.

**“ДУЛААНЫ ТАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ”
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

2026.03.30